

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20<sup>23</sup> оны 8 сарын 02 өдөр

№ R-2023-66

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус  
хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хороо ("СЗХ")-ны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын 2.2 дахь хэсэг, ХасБанк ("Банк")-ны Дүрэм, Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл ("ТУЗ")-ийн 2023 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн хурлаар хэлэлцээд гарсан шийдвэрийг үндэслэн:

## ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банк нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн SR-2023-03 дугаар тогтоолоор үүрэг болгосны дагуу, Монголбанкны 2023 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А-1/374 дугаар албан бичгээр өгсөн зөвшөөрөл, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 179 дугаар тогтоолыг тус тус үндэслэн нийтэд хувьцаагаа санал болгон амжилттай арилжаалсныг;
2. Өөрчлөн байгуулагдсан Банкны Дүрэм батлах болон холбогдох бусад шийдвэрийг гаргах зорилгоор Банкны анхдугаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах нь зүйтэй гэж Банкны ТУЗ үзсэн болохыг тус тус тэмдэглэв.

## ТОГТООХ нь:

1. Банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 13:00 цагт (Улаанбаатар хотын цагаар) Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энх Тайвны Өргөн чөлөө -17 хаягт байрлах Блю Скай Зочид Буудлын хурлын танхимд (танхим болон цахим хосолсон байдлаар) зарлан хуралдуулсугай.
2. Хурлыг танхим болон цахим байдлаар хосолсон хэлбэрээр зохион байгуулсугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Банкны ТУЗ-ийн дарга Санжай Гүптаг зарласугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Зохион байгуулах комиссын даргаар Банкны Ерөнхий аудитор Э.Ундармааг томилсугай. Тус комиссын гишүүдийг холбогдох дотоод журмын дагуу томилохыг Гүйцэтгэх Удирдлагад үүрэг болгосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай мэдэгдлийг 2023 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн дотор СЗХ болон Монголын Хөрөнгийн Бирж ("МХБ")-д хүргүүлэхийг ТУЗ-ийн Ажлын албанд даалгасугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулах тухай зар мэдээг МХБ-ийн цахим хуудас, өдөр тутмын сонин, Банкны албан ёсны веб сайт ([www.xacbank.mn](http://www.xacbank.mn)), сошиал орчин дахь албан ёсны хаягаар болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2023 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, зарын давталтыг тийнхүү нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх зарласан хэлбэрээр дахин нэг удаа нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдөр байхаар тогтоосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гаргах шийдвэрийн төсөл, хурлын танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2023 оны 8 дугаар сарын 12-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлэхийг Зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын хэлэлцэх асуудлыг 1 дүгээр хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичгийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дэгийг 4 дүгээр хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын саналын хуудсыг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналыг урьдчилан 2023 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 17:00 цаг хүртэл хугацаанд цаасаар брокер дилерийн компаниар дамжуулан, эсхүл Банкны нийт салбар, тооцооны төвөөр дамжуулан авах, эсхүл цахимаар дамжуулан авах боломжийг бүрдүүлэн ажиллахыг хурал Зохион байгуулах комисст даалгасугай.
11. Хувьцаа эзэмшигчдээс урьдчилан цаасаар болон цахимаар өгсөн саналыг хувьцаа эзэмшигчдийн хурал дээр өгсөн саналтай нэгтгэн, тооллогын дүнд оруулан тооцохыг Тооллогын комисст даалгасугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гаргасан шийдвэр, бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд МХБ, СЗХ-д хүргүүлэхийг ТУЗ-ийн Ажлын албанд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ